



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/175

Арвайхээр

**Шуурхай бүлэг томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "б", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, 15.1.4, 15.1.5, 15.2, 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.3 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 13 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хужирт суманд Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахал өвчний батлагдсан тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан хариу арга хэмжээ, удирдлага зохион байгуулалтаар хангах шуурхай бүлгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Бүлгийн ахлагч: И.Доржсүрэн (аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд: Г.Ганбаатар (аймгийн Онцгой байдлын газрын эрэн хайх, авах салбарын дарга)

Б.Шүрэнцэцэг (аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын эрүүл ахуйн улсын байцаагч)

Н.Оюунтуяа (аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн дарга)

Ц.Сонинбаяр (аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын халдварт бус өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн)

Ц.Анхтуяа (Эрүүл мэндийн газрын ахмад настан)

Ц.Эрдэнэтуяа (Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн халдвартын тасгийн эмч)

Ц.Үржинчимэг (Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн сувилагч)

С.Хоролмаа (аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн лабораторийн их эмч тархвар судлаач)

Б.Цэндхорол (аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн ариутгагч)

Х.Мөнхцэцэг (Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн лаборант)

В.Төмөртоогоо (Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн жолооч)

С.Лхагвацэрэн (аймгийн Засаг даргын Тамгын газрын жолооч)


О.Оюунтүлхүүр (Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн сувилагч)

М.Наранзул (Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн үйлчлэгч)

2.Голомт бүхий нутаг дэвсгэрт цар тахлын нэг, хоёрдугаар хавьтлыг тогтоох, хавьтал бүхий иргэдийг тусгаарлан ажиглах байранд тусгаарлаж, PCR шинжилгээнд хамруулах, тархалтыг бууруулан ажиллахыг шуурхай бүлгийн ахлагч (И.Доржсүрэн)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Онцгой комиссын орлогч, Онцгой байдлын газрын дарга (дэд хурандаа Д.Одонбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100378